



## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

### “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/12 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын уламжлалт Сар шинийн баярыг тохиолдуулан “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг дүүрэгт 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 1 дүгээр хорооны Биеийн тамир, спорт хорооны зааланд зохион байгуулсугай.

2. Зохион байгуулах арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг чанартай зохион байгуулж, үндэсний үйлдвэрлэгч, жижиг дунд үйлдвэр эрхлэгч, иргэдийг өргөнөөр оролцуулан үзэсгэлэн худалдаа зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв (М.Өсөхдэлгэр)-д, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэд, олон нийтэд сурталчлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Д.Эрдэнэтуяа), 1, 2 дугаар хороо (Н.Нямзав, Б.Батзориг)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Арга хэмжээнд зарцуулагдах 292,000 (Хоёр зуун ерэн хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Дээрх арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш 7 хоногийн дотор тайланг ирүүлж, үр дүнг танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 02 сарын 01 ны өдрийн 101 дугаар  
захирамжийн хавсралт



“ЦАГААН САР” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД  
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)
1.	Анонс (4x3)	м <sup>2</sup>	12	16,000	192,000
2.	Заалны түрээс	цаг	5	20,000	100,000
Нийт дүн					292,000